



## “СИ И СИ ИНВЕСТМЕНТ ББСБ” ХХК-ИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь “СИ И СИ ИНВЕСТМЕНТ Банк Бус Санхүүгийн Байгууллага” ХХК /цаашид ББСБ гэх/- Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид ТУЗ гэх/ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохицтой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тоитмол хяналт тавих үйл ажиллагаатай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. ББСБ-ын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ Монгол улсын Иргэний хууль, Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс” болон бусад холбогдох хууль тоогоомж, энэхүү журмыг удирдлага болгоно.

1.2. Энэхүү журамд нэмэлт өөрчлөлт оруулах болон хүчингүй болгох асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ.

### **ХОЁР. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЗАРЧИМ**

2.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.

2.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн компанийд учирч болзошгүй эрсдэлийг үнэлэх, түүнийг хэрхэн удирдах талаар бодит, бүрэн ойлголттой байх шаардлагатай.

2.3. ТУЗ нь компанийн зорилго, алсын хараатай уялдуулан хүлээж болох эрсдэлийн төрөл, хэмжээ хязгаарыг тодорхойлох чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.4. Төлөөлөн удирдах зөвлөл нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байна.

2.5. Эрсдэлийн хороо нь гурваас доошигүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна.

2.6. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хороопын хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тоитмол тайлagnана.

2.7. Эрсдэлийн хороо нь компанийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг тоитмол хянах, эрсдэлийг хянах, илрүүлэх дотоод хяналтын тогтолцооны үйл ажиллагааны үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч, холбогдох зөвлөмжийг төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна.

2.8. Компанид тулгарч байгаа эрсдэл, тэдгээрийг хэрхэн удирдаж байгаа талаар бүрэн гүйцэд мэдээллийг гүйцэтгэх удирдлагаас эрсдэлийн хороонд тоитмол хүргүүлэн заавар, удирдамж авч байх харилцааг нэвтрүүлсэн байна.

2.9. Эрсдэлийн хорооны чиг үүргийг аудитын хороонд хариуцуулж болох ба энэ тохиолдолд эрсдэлийн удирдлагын тогтолцоо, журам, хэрэгжилтийн талаарх мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсанд дэлгэрэнгүйгээр тайлбарлана.

2.10. Эрсдэлийн хороо нь компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа ТУЗ-д тайлагнана.

2.11. Энэ журамд дурдсан мэдээллийг тайлагнаадаа заавал бие даасан тогтвортой байдлын тайлан гаргах албагүй боловч олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу тогтвортой байдлын тайлан гаргадаг бол түүнийгээ эш татах замаар “Компанийн засаглалын кодекс”-ийн шаардлагыг хангаж болно

2.12. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.

2.13. Төлөөлөн удирдах зөвлөл нь комплайнсын хяналтын заавар, жил бүрийн төсвийг батлан хүний нөөцийг томилж, шууд харьцана.

2.14. Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага нь комплайнсын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлж буй этгээдэд шаардлагатай туслалцаа, дэмжлэгийг үзүүлж, бие даасан хараат бус байдлыг хангана.

### ГУРАВ.ЭРСДЭЛИЙН СОЁЛ

3.1 ББСБ-ын ажилтан бүр өөрийн хариуцсан ажлын чиг үүрэг, эрх хэмжээ, хариуцлагын хүрээнд эрсдэлийг таньж мэдэх, урьдчилан сэргийлэх, илрүүлэх, үнэлэх, тайлагнах үүрэгтэй.

3.2 ББСБ-ын удирдлагууд нь эрсдэлийн соёлыг бий болгох, түгээх, ажилтнуудад эрсдэлийн талаарх ойлголт, эрсдэлээс урьдчилан сэргийлэх соёлыг бий болгох зорилгоор өөрийн хариуцсан нэгжийн бодлого, журам заавар, бүтээгдэхүүн, үйл ажиллагааны талаарх сургалтыг зохион байгуулах, мэдээллээр хангах ажлыг тогтмол зохион байгуулна.

### ДӨРӨВ.ХАМГААЛАЛТЫН БҮСҮҮД

4.1. ББСБ-ын эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь хамгаалалтын гурван бүсийн зарчимд тулгуурлах ба тэдгээр нь дараах чиг, үүргүүдтэй байна. Үүнд:

4.1.1. **Хамгаалалтын нэгдүгээр бүс** - Бизнес болон түүнд дэмжлэг үзүүлэгч нэгжүүд байх бөгөөд эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж ажиллана. Өөрөөр хэлбэл өөрийн хариуцан буй үйл ажиллагаа, бизнесийн эрсдэлийг хариуцан ажиллах бөгөөд эрсдэлийг үнэлэх, хянах, тайлагнах, бууруулж ажиллах чиг үүрэгтэй байна.

4.1.2. **Хамгаалалтын хоёрдугаар бүс** - Хууль, Эрсдэлийн удирдлагын газар байх бөгөөд эрсдэлийн удирдлагын хяналтыг хэрэгжүүлж ажиллана. Өөрөөр хэлбэл эрсдэлийн удирдлагын тогтолцоог тодорхойлох, журам зааврыг Боловсруулах, шинэчлэх, эрсдэлийн лимитийг тогтоох хянах, түүнд мониторинг хийх бөгөөд хамгаалалтын 1-р бүсэд чиглэл, зөвлөмж өгнө.

4.1.3. **Хамгаалалтын гуравдугаар бүс** - Дотоод аудитын газар байна. Дотоод аудитын газар нь ТУЗ-д хараат бус баталгаажуулалтыг өгөх ба ингэхдээ Хамгаалалтын 1 болон 2-р бүсийн эрсдэлийг удирдах үйл ажиллагааны ур дүнтэй байдалд хараат бусаар үнэлэлт дүгнэлт өгч ажиллана.

## ТАВ. ЭРСДЭЛИЙН ТӨРӨЛ, АВАХ АРГА ХЭМЖЭЭ

- 5.1. БСБ-д учирч болох эрсдэлийг дараах байдлаар ангила. Үүнд:
- 5.1.1. **Зээлийн эрсдэл:** Зээлдэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүйн улмаас хүлээж болзошгүй алдагдал.  
**Авах арга хэмжээ:** Зээлийн эрсдэлийн сан байгуулах, эргэн төлөлтийн зөрчлийн мэдээг тогтмол тооцоолох, зээлийн эрсдэлийн төвшингөөр активыг жигнэх, дотоодын зээлдэгчийн зээлжих зэрэглэлийн оноо тооцох.
- 5.1.2. **Зээлийн төвлөрлийн эрсдэл:** Нэг болон харилцан хамааралтай зээлдэгч эсвэл нэг салбарт зээлийг төвлөрүүлж олгосны улмаас үүсэх эрсдэл.  
**Авах арга хэмжээ:** Санхүүгийн зохицуулах хорооны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн дагуу нэг зээлдэгчид болон хамаарал бүхий этээдүүдэд олгох зээлийн хэмжээг тогтоох. Тогтоосон хэмжээнээс хэтрүүлэлгүй хяналттай байх.
- 5.1.3. **Зах зээлийн эрсдэл:** зах зээл, эдийн засгийн хямрал, ханш, хүү, инфляцын огцом өөрчлөлтөөс үүдэн орлого болон хөрөнгийн хэмжээнд хүлээж болзошгүй алдагдал.  
**Авах арга хэмжээ:** Value at risk (VaR) эрсдэлийн хэмжигдэхүүн, GAP шинжилгээ, бодит өртөг, макро орчны тогтвортой байдал, симуляци, зах зээлийн эрсдэлийн төвшингээр активыг жигнэн байнгын хяналттай байх.
- 5.1.4. **Өөрийн хөрөнгийн эрсдэл:** Өөрийн хөрөнгийн хүрэлцээ байхгүйгээс бизнесийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх чадваргүй болох, эсвэл зохицуулагч байгууллагын өөрийн хөрөнгийн хүрэлцээний шаардлагыг хангаж чадахгүй болох.  
**Авах арга хэмжээ:** Санхүүгийн зохицуулах хорооны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт тогтоох. Бонд болон итгэлцлийг тогтоосон дээд хэмжээнээс давуулж татахгүй байх.
- 5.1.5. **Хөрвөх чадварын эрсдэл:** өөрийн хөрөнгийн хүрэлцээ алдагдаагүй боловч харилцагчийн өмнө хүлээсэн үүргээ цаг тухайд нь биелүүлэх чадваргүй болох, эсвэл тухайн үүргийг биелүүлэхэд ихээхэн хэмжээний зардал гарах нөхцөл байдлаас хүлээж болзошгүй алдагдал.  
**Авах арга хэмжээ:** Хөрвөх чадварын GAP шинжилгээ, хөрвөх чадварын харьцаа болон бусад шалгуур үзүүлэлтүүдийн хангалтыг баримтлах.
- 5.1.6. **Үйл ажиллагааны эрсдэл:** дотоод процесс, хүний неөц болон системийн үйл ажиллагаа хангалтгүй буюу доголдолтой, эсвэл гаднын хүчин зүйлсийн улмаас хүлээж болзошгүй алдагдал. Хууль эрх зүйн эрсдэл нь үйл ажиллагааны эрсдэлд хамаарна.  
**Авах арга хэмжээ:** Үйл ажиллагааны эрсдэл үйл ажиллагааны эрсдэлээс үүсэж гарсан алдагдлын статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийх, үндсэн хүчин зүйлүүдэд стандартчилагдсан аргачлалаар эрсдэлийг тооцох.
- 5.1.7. **Аюулгүй байдлын эрсдэл:** Бодит болон мэдээллийн аюулгүй байдал алдагдах, мэдээллийн системд халдлага хийх эсвэл түүнийг зөрчсөний улмаас үүсэх гарз хохирол болон алдагдал.  
**Авах арга хэмжээ:** ISO 27001:2013 Мэдээллийн технологи, Аюулгүй байдлын арга техник. Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоог үйл ажиллагаандaa нэвтрүүлж сертификат авах. Кiber аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийлгэх.
- 5.1.8. **Ёс зүйн эрсдэл:** ёс зүйн дүрмийг зөрчсөн эсвэл харилцагчтай шударга харилцах зарчмыг хэрэгжүүлэгүйн улмаас гарч болзошгүй алдагдал.  
**Авах арга хэмжээ:** Байгууллагын дотоод дүрэм, журамд ёс зүйн хэм хэмжээ, хариуцлагыг бүрэн тусгаж өгөх. Ажилтнуудад ёс зүйн үнэлгээ хийх, сургал явуулах аргачлал боловсруулж мөрдөж ажиллах.
- 5.1.9. **Хянан нийцүүлэлтийн эрсдэл:** Хууль тогтоомж, дүрэм журам, ёс зүйн стандарт, байгууллагын дотоод бодлого зэрэг зөрчигдсөнөөс үүдэн нэр хүндээ алдах, тусгай

зөвшөөрөл, лицензээ хураалгах, тортгууль, акт тавиулах, санхүүгийн хувьд үүсэх алдагдлыг хэлнэ. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааг хангалтгүй хэрэгжүүлсэн, харилцагчийг таныж мэдэх үйл ажиллагааг хэрэгжүүлэгүйгээс үүдэн гарах эрсдэл мөн үүнд хамаарна.

**Авах арга хэмжээ:** Мөнгө угаах болон терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх. Зохицуулагч байгууллага болон бусад эрх бүхий байгууллагаас гаргасан бодлого дүрэм, журамд мэдрэг хандаж уаг тухай бүр нийцүүлэн ажиллах.

- 5.1.10. **Нэр хүндийн эрсдэл:** олон нийтийн сорог ойлголтоос үүдэн байгууллагын нэр хүндэд хохирол учрах, улмаар орлогын хэмжээнд алдагдал үүсэх эрсдэл.
- Авах арга хэмжээ:** Байгууллагын дотоод нууц хадгалах гэрээг ажилтан, хамтран ажиллагч байгууллага бүртэй байгуулах. Байгууллагын нэр хүндэд халдсан эсвэл хохирол учруулахаар зүйлд цаг алдалгүй арга хэмжээ авч ажиллах.
- 5.1.11. **Стратегийн эрсдэл:** нөөцийг үр ашиггүй зарцуулснаас үүдэн бизнесийн болон үйл ажиллагааны зорилгодоо хүрч чадахгүйд хүрэх, бизнесийн шийдлийн хэрэгжилт муу, өөрчлөгдөж буй нөхцөл дасан зохицох чадвар бага зэргээс үүдэн бизнесийн боломжоо алдах, алдагдал хүлээх эрсдэл.
- Авах арга хэмжээ:** Бизнес төлөвлөгөөг богино, дунд, урт хугацаагаар боловсруулан мөрдөх. Бизнесийн зах зээлийн өөрчлөлт, хууль эрх зүйн өөрчлөлт болон бизнест нөлөөлж болохуйц зүйл тохиолдвол цаг тухай бүр бизнес төлөвлөгөө болон стратегийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах.
- 5.2. Хамгаалалтын нэг болон хоёрдугаар бүсүүд нь дараах байдлаар эрсдэлийн төрлүүдэд хуваарилагдана.

Эрсдэлийн төрөл	Хамгаалалтын 1 бүс	Хамгаалалтын 2 бүс
Зээлийн эрсдэл	Бизнесийн нэгжүүд	Эрсдэлийн удирдлагын нэгж
Зээлийн төвлөрлийн эрсдэл	Бизнесийн нэгжүүд	Эрсдэлийн удирдлагын нэгж
Зах зээлийн эрсдэл	Санхүүгийн удирдлага хөрөнгө зохицуулалт хариуцсан нэгж	Эрсдэлийн удирдлагын нэгж
Өөрийн хөрөнгийн эрсдэл	Санхүүгийн удирдлага хөрөнгө зохицуулалт хариуцсан нэгж	Эрсдэлийн удирдлагын нэгж
Хөрвөх чадварын эрсдэл	Санхүүгийн удирдлага хөрөнгө зохицуулалт хариуцсан нэгж	Эрсдэлийн удирдлагын нэгж
Үйл ажиллагааны эрсдэл	Бүх нэгжүүд	Хууль, эрсдэлийн удирдлагын нэгж
Аюулгүй байдлын эрсдэл	Бүх нэгжүүд	Мэдээллийн болон бодит аюулгүй байдал хариуцсан нэгж
Ёс зүйн эрсдэл	Бүх нэгжүүд	Хууль, эрсдэлийн удирдлагын нэгж
Хянан нийцүүлэлтийн	Бизнес/Арын албаны нэгжүүд	Хууль, эрсдэлийн удирдлагын нэгж

ЭРСДЭЛ		
Нэр хүндийн эрсдэл	Бүх нэгжүүд	Хууль, эрсдэлийн удирдлагын нэгж
Стратегийн эрсдэл	Гүйцэтгэх захидал	ТУЗ

## ЗУРГАА. ЭРСДЭЛИЙН ЗАСАГЛАЛ

6.1. ББСБ-ын эрсдэлийн засаглал нь дараах хэсгээс бүрдэнэ.

6.1.1. Хамгаалалтын гурван бүс буюу эрсдэлийг илрүүлэх, бууруулах, хянах, хүлээн зөвшөөрөх чиг үүрэг бухий өдөр тутмын эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа.

6.1.2. Засаглалын бичиг баримтууд буюу эрсдэлийн удирдлагын бодлого, холбогдох эрсдэлүүдийг удирдах ерөнхий журмууд болон тэдгээрийн үйл ажиллагааг зохицуулсан журам, стандарт болон зааврууд.

6.1.3. Засаглалын хороод буюу ББСБ-ын эрсдэлийн удирдлагын тогтолцоо, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээний удирдлагын хэрэгжилтэд хяналт тавих хороод.

## ДОЛОО. ЭРСДЭЛИЙН ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ХЭМ ХЭМЖЭЭ

7.1. ББСБ нь эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээг хууль тогтоомж, зохицуулагч байгууллагын тавьсан хязгаар үзүүлэлтүүд, бизнесийн болон стратеги зорилтын хүрээнд хүлээж болох эрсдэл, тэдгээрийг удирдах хэм хэмжээнд тулгуурлан эрсдэлийн төрөл бүрээр ялгатай тогтоож, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнаж ажиллана

## НАЙМ. ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ БА ТАЙЛАГНАЛТ

8.1. ББСБ нь бүхий л үйл ажиллагаандаа хяналтын тогтолцоог бий болгож, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхийг зорих бөгөөд болзошгүй эсвэл гэнэтийн эрсдэлийн тохиолдолд хүлээж болзошгүй эрсдэлийг тодорхойлох, тэдгээрийг цаг алдалгүй удирдах зорилгоор эрсдэлийн үнэлгээ болон дүн шинжилгээг хийдэг байна.

8.2. ББСБ нь эрсдэлийн тайланг бэлтгэн сар бур ББСБ-ын Актив Пассив, Эрсдэлийн удирдлагын хороонд, улирал тутамд Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороонд танилцуулна.

## ЕС. НЭР ХҮНДИЙН БОЛОН СТРАТЕГИЙН ЭРСДЭЛ

9.1. Нэр хүндийн эрсдэл - Байгууллагын нэр хүндэд хохирол учруулж, улмаар орлогын хэмжээнд алдагдал үүсэх эрсдэлийг хэлэх бөгөөд нягтлан бүр ёс зүйн дүрмийг чандлан баримтлаж, харилцагчтай харилцах харилцаа, үйлдэл, мэдлэг чадвар, үйл ажиллагаагаараа ББСБ-ын нэр хүндийг хамгаалах уурэгтэй.

- Хамгаалалтын нэгдүгээр бүс буюу Бизнесийн нэгжүүд

Гүйцэтгэх удирдлага болон салбар нэгжийн удирдлагууд нь ажилтнууддаа ББСБ-ын нэр хүнд, үнэ цэнийн талаарх ойлголт мэдээллийг өгөх, нэр хүндийн эрсдэлээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар сургалт мэдээллийг тогтмол өгөх үүрэгтэй. ББСБ-ын ажилтан бүр ББСБ-ын бизнес, үйл ажиллагаа, нэр хүндэд халдсан эсвэл учирч болзошгүй аюул занал байгааг илрүүлсэн, мэдсэн

даруй өөрийн удирдлагад эсвэл Хууль, Эрсдэлийн удирдлагын газар болон Гүйцэтгэх удирдлагад мэдэгдэх үүрэгтэй ба ингэснээр тухайн эрсдэлээс цаг алдалгүй сэргийлэх, бууруулах ач холбогдолтой.

- Хамгаалалтын хоёрдугаар бүс буюу Хууль, Эрсдэлийн удирдлагын нэгж

Эрсдэлийн удирдлага харинцсан нэгж нь ББСБ-ын иэр хүндэд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах, холбогдох газар нэгжүүдтэй хамтран дэмжин ажиллана Уйл ажиллагаанаас үүдэлтэй иэр хүндийн эрсдэлийг үнэлэх, хянах процессыг ББСБ-ын үйл ажиллагааны эрсдэлийг удирдах үйл ажиллагааны журмаар зохицуулсан байна.

- Хамгаалалтын гуравдугаар бүс буюу Дотоод аудитын газар

Дотоод аудитын газар нь хамгаалалтын нэг болон хоёрдугаар бүсийн иэр хүндийн эрсдэлээс сэргийлэх үйл ажиллагаанд хараат бус баталгаажуулалтыг хийнэ.

**9.2. Стратегийн эрсдэл — Байгууллагын нөөцийг үр ашиггүй зарцуулснаас үүдэн бизнесийн болон үйл ажиллагааны зорилгодоо хүрч чадахгүйд хүрэх, бизнесийн шийдвэлийн хэрэгжилт муу, өөрчлөгдөж буй нөхцөлд дасан зохицох чадвар бага зэргээс үүдэн бизнесийн боломжкоо алдах, алдагдал хүлээх эрсдэлийг хэлнэ.**

#### » Хамгаалалтын нэгдүгээр бүс буюу ББСБ-ын Гүйцэтгэх захирал

Гүйцэтгэх захирал нь ББСБ-ын эрхэм зорилго, үнэт зүйлсийн хүрээнд ББСБ-ын орлогын эх үүсвэрт зорилго, ашигтай байх бизнес төлөвлөгөө болон холбогдох шийдвэрийг гаргана. Гэвч эдийн засгийн, зохицуулагч байгууллагын эсвэл өрсөлдөөний зэрэг сөрөг нөлөөлүүд нь алдагдалд хүргэж болзошгүй байдаг тул стратегийн эрсдлийг бүрэн бууруулах боломжгүй юм.

- Хамгаалалтын хоёрдугаар бүс буюу ББСБ-ын Төлөөлөн удирдах зөвлөл

Стратегийн голлох шийдвэрийг хянан үзэх, сорих, батлах, Стратегийн үндсэн шийдвэрүүд болон шийдвэр гаргах үйл явцын талаар Гүйцэтгэх захирал болон удирдлагын багт санал, зөвлөмж өгөх нь Төлөөлөн удирдах эөвлөлийн үүрэг байна.

- Хамгаалалтын гуравдугаар бүс буюу Дотоод аудитын газар

Дотоод аудитын газар нь стратегийн шийдвэр гаргах процесс болон стандартад хараат бус баталгаажуулалтыг хийнэ.